

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ИННОВАЦИД ЭРДЭМТЭД, БАГШ НАРЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Ц.Оюун, доктор (Sc.D), профессор, МУБИС

Abstract: In this article, thousands of scientists and professors working in the field of higher education, are paying their attention to the development of higher education and the power of innovation potential while focusing on the issues and views raised the idea of consolidation. The explanation of the concepts of innovation and development of higher education and economic advancement of the country mentioned about the importance of innovation incentives.

The issues concerning the innovation in the higher education sector-comprising colleges, universities, innovation centers, scientists, and university teaching and research staffs to think creatively, and what can be done about ideas, observations and theories have been taken into consideration for the basic research.

The qualitative change in higher education and universities is essentially an innovation-based reform. Innovation is a search to create new products, new services, new methods and new management with competitive skills. However, the innovation as the only advanced technology and the invention have been completely not considered.

In order to prepare highly-qualified professionals with the competitive skills in the field of education in the region as well as in the world, those activities such as programs, theory, methodology and reforms can make great contribution to the development of the country. It, in turn, greatly depends on them. Finally, I would like to note that it will be a good start if MNUE makes reforms on the activities, outputs, and the solution of its management team.

Түлх ү үр үг: инноваци, дэлхий нийтийн хандлага, бүтээгч их сургууль, энтрепренёр их сургууль, либераль сэтгэлгээ, magna багш, хөгжсөн багш

Удиртгал

Инновацийн тухай ойлголт: Боловсрол нь аливаа улс орны хөгжил, дэвшлийн үндэс бөгөөд энэ агуулгаараа хувь хүн, нийгэмд томоохон хүлээлт, хэрэгцээг үүсгэж байдаг үнэт зүйл билээ. Өнөөдрийн дээд боловсролын зорилго, суралцагчдад дээд боловсрол олгох шинэ тогтолцоог бүрдүүлэн, олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулснаар нийгэмшил, цогц чадамж, хөгжлийн чанараар дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн

бэлтгэж улс орноо хөгжүүлэхэд чиглэж байна. Энэ нийтлэг зорилго дээд боловсролын салбарт ажилладаг удирдлага, багш эрдэмтэд, судлаачдын хүлээх нэгэн үүрэг байдаг. Иймээс ч 2015 оны хичээлийн шинэ жилийн нээлтэн дээр, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайд Л.Гантөмөр дээд боловсролын салбар, их, дээд сургуулийн удирдлага, эрдэмтэн, багш, ажилтан ажиллагсад хандаж хэлсэн үгэндээ, “...сургалт, судалгаа, инновацийг хөгжүүлэх ажилдаа эзэн болж, үр бүтээлтэй ажиллах”-ыг уриалаад, “Ур чадвартай залуу үе, ард түмэн, тэдний мэдлэг, тасралтгүй суралцах чадвар бол тогтвортой хөгжил, эдийн засгийн нөөцийн хамгийн чухал хүчин зүйл, уршиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндэс” гэдгийг тэмдэглэжээ. Мөн боловсрол, шинжлэх ухааны чанарын шинэчлэлийн бодлогын нэг бүтээлч хэсгийг, эрдэм шинжилгээний ажлын чанарыг сайжруулан, судалгаа, инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулан хөгжүүлэх явдал гэж томъёолжээ.

2014 - 2015 оны боловсролын статистикаас харвал, Монголын зуугаад их, дээд сургуульд 13 мянга гаруй эрдэмтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байгаа нь энэ салбарын хөгжил дэвшил, инноваци, өрсөлдөөний талбарт том орон зай эзэлж, дээд боловсролын хувь заяаг атгалцаж байгаа хэрэг мөн.

Дээд боловсролд хийх чанарын өөрчлөлт үндсэндээ шинэчлэлийн инноваци байдаг. Үүнийг дээд боловсролын салбарын хүрээнд хийх их, дээд сургуулийн хүрээнд хийх гэж ялгаатай авч үзэх ч үр дүн нь харилцан хамаарал бүхий нэгэн зүйл юм. Дээд боловсролын салбарт хийх чанарын шинэчлэл бүхий инноваци нь мэргэжлийн бодлогын яам, дээд боловсролын салбар, их дээд сургуулиас авахуулаад бүрэлдэхүүн сургууль, судалгааны төв, нэгж тэнхим, эрдэмтэн багш, судлаач хүртэл дээрээс, доош, доороос дээш харилцан хоёр урсгалаар хэрэгждэг байна.

Инноваци хэмээх үгийн агуулгыг толь бичгүүдээс үзвэл, үндсэн утга нь innovate-шинийг нэвтрүүлэх, өөрчлөлт хийх, innovation-шинэ зүйл оруулах, шинэчлэл шинэ санаачилга буй болгох үйл гэж В.К. Мюллерийн “Англо-русский словарь, 1991, Москва. тольд бичсэн бол, Д. Алтангэрэлийн “Англи-монгол толь,

2002 ”-д innovate-шинэ зүйл сэдэх, өөрчлөлт шинэ ч лэл хийх, шинээр санаачлах, innovation-шинэ члэл хэмээн утгачилсан байна. XIX зууны дундуур Германы соёл судлаачдын бүтээлүүдэд “инноваци” хэмээх ойлголт соёл нэвтрүүлэх утга санаагаар анх орж ирсэн бол XX зууны эхээр Австрийн эрдэмтэн Й.Шумпетер, Оросын эрдэмтэн Н.Кондратьев нар “эдийн засгийн хөгжилд шинэчлэл, өөрчлөлт оруулах замаар хямралыг даван туулах хэрэгсэл...” гэсэн утгаар ашигласан нь үндсэн утгаа одоо хэр алдаагүй, харин ч баяжсан юм байна.

Инновацийг үндсэнд нь, ямар нэгэн бүтээлч санаанаас бодит мэдлэгийг бий болгон түүнийгээ үйлдвэрлэлд үйлчилгээнд хэрэглэх, өрсөлдөх чадвар бүхий шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ, шинэ арга зүй, менежмент болгох үйл ажиллагаа гэж ойлгож болох аж. Ямартай ч инноваци нь дээд боловсролын салбар, их сургууль, хувь хүмүүсийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх шинэ ололт, дэвшилтэт бүтээлч зүйл, шинэ сэтгэлгээ, шинэчлэл хийх дорвитой үйл мөн. Тэрчлэн шинэ бүтээгдэхүүн, эсвэл чанарын шаардлага хангасан үйл ажиллагаанд шингэсэн шинэлэг санаа ч инновацийн нэг тулгуур болдог байна.

Нэг бүрдвэрт багтдаг инноваци, бүтээлч шинэ санаа, шинэчлэл гэсэн гурван ойлголтыг дотор нь ялган авч үзэх тухай судлаачдын өөр өөр байр суурь бий. Тэдгээрийг нэгтгэн тайлбарлавал:

- Бүтээлч шинэ санаа гэх ойлголтод шинэ санаа, сэдэл, төсөөллийг оруулах агаад энэ нь, нээлт, зохион бүтээлт, патент, саналын хэлбэртэй шинэ санаа, шинэ юмуу боловсронгуй болгосон бүтээгдэхүүн, ноу хау, стандарт, зөвлөгөө, аргачлалын хэлбэрээр буюу зах зээлийн судалгааны үр дүнгийн хэлбэрээр илэрдэг байна. Шинэ санаа, зүйлийг өөрийнхөө хэрэгцээг хангах, худалдах зорилгоор бүтээж болдог байна.
- Инноваци гэх ойлголт бол шинэ сэдлээ бодит бүтээгдэхүүн, үйлчилгээ болгох явц аж. Ингэхийн тулд маркетингийн судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажил, зохион байгуулалт, бэлтгэл хангалт, үр дүнг тодорхойлох зэрэг олон дамжлагыг давдаг. Энэ бүхний дараах шинэ зүйл нэвтрүүлсэн эцсийн үр дүн нь инноваци болдог.
- Шинэчлэл буюу “reform” гэх ойлголт нь макро түвшний өргөн хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийг хэлэх ажээ. Инноваци нь макро түвшинг хангах микро түвшингүүдэд өрнөж буй шинэчлэлүүдийн

тухай ойлголт юм. Ингэхээр, бүтээлч шинэ санаанууд инноваци болон үргэлжилж, эцсийн үр дагавар нь шинэчлэлийг авчирдаг. Үндсэндээ инноваци бол өөрчлөлт дэвшил, шинэчлэлийг авчрах шинэ хандлага, сэдлэг, үр бүтээлт санаа бүхий үр дүн- цогц мөн аж.

ҮНДСЭН ХЭСЭГ

А. Инноваци руу тэмүүлэх нь

1990-ээд оны дунд үеэс дээд боловсролын хөгжил дэвшил, бодлогын цар хүрээ тэлж дэлхий нийтийн хандлагатай болж, их, дээд сургуулийн үйл ажиллагаанд даяаршилын бодлого бүхий дангааршилын хандлага давамгайлах болсон. Энэ хандлага өнөөдөр улам эрчимжин, манай эрдэмтэн, багш нарын судалгаанд байр сууриа эзэлж, тэдний хувь нэмэр дээд боловсролын хэтийн ба ойрын бодлогод тусгалаа олсоор байгаа юм. Улс орныхоо хөгжлийг тэргүүлэгч, “мэдлэгт суурилсан нийгэм”-ийг бүтээгч гол хүч нь манай их сургуулиуд гэдэгт хэн ч эргэлздэггүй. Энэ хандлагаар харвал, монголын их сургуулиуд өнөөдөр энтрепренёр их сургууль болох хандлага руу явах, сургалт-судалгаа, эрдэм шинжилгээ-бизнес чиглэлтэй их сургууль болоход тэмүүлэх, зорих хэрэгтэй болсон ажээ. Өөрөөр хэлбэл, мэдлэг бүтээдэг их сургууль, бизнес бүтээдэг бүтээгч их сургууль болох ирээдүйг сонгох хэрэгтэй болжээ.

Ч.Ганзориг, С.Төмөр-Очир нарын эрдэмтэд “Монгол Улсад өндөр технологийн аж үйлдвэр, инновацийг хөгжүүлэхэд их сургуулийн гүйцэтгэх үүрэг”, “Энтрепренёр судалгааны их сургуулийн хувьд” илтгэлдээ, их сургуулийн хөгжлийн хандлагыг:

“Сургалтад суурилсан их сургуулиас сургалт, судалгааны их сургуулийн шатлалд шилжиж улмаар, сургалт, судалгаа, эдийн засаг, нийгмийн баримжаатай, энтрепренёр их сургуульд дэвшин, эцэст нь, өндөр хөгжил бүхий сургалт, судалгаа, хүрээлэн буй орчны эдийн засаг, нийгмийн баримжаатай, тогтвортой хөгжлийн түвшинд хүрч очих болно” хэмээн үзжээ. Үүнийгээ тэд дэлхийн их сургуулиудын хөгжлийн шатлал, хандлага хэмээн тайлбарласан байдаг. Монгол Улсын Их Сургуулийн гэхэд л, стратегийн зорилтоо судалгаанд суурилсан их сургууль болж, профессорын багийн тогтолцоонд шилжих, үндэсний болон салбар, салбар дундын нээлттэй судалгааны төв, нэгдсэн лабораториуд байгуулах, оюуны өмч, технологи дамжуулалт, эхлэлийн гарааны компани байгуулахын хамт инновацийн

тогтолцоо бүрдүүлэх явдал хэмээжээ. Мөн 2020 он гэхэд энтрепренёр судалгааны их сургууль буюу дэлхийн их сургуулиудын хөгжлийн 3 дахь загварт шилжих эрхэм зорилготой ажээ. Иймд МУИС-ийн эрдэмтэд, багш, судлаачид энэхүү эрхэм зорилгыг хэрэгжүүлэх нэгэн чухал хүч нөөц нь юм.

Ер нь, дээд боловсролын салбар, их, дээд сургуулиудын нэг эрхэм зүйл бол дэлхийн хэмжээнд үзэж буй дээд боловсролын үзэл баримтлалд нийцсэн, тэдний жишиг, үзүүлэлтэд ойртсон бодлого, үзэл баримтлал байх бөгөөд, үйл ажиллагаандаа мэдлэг, шинжлэх ухааныг үйлдвэрлэл, бизнес сэтгэлгээтэй ухаалаг уялдуулах, инноваци эрэл хайлт нэвтрүүлэн дэвшил гаргах зэрэг хэтийг харсан бодлого чухал болоод байгааг их сургуулийн удирдлагууд, судлаачид тэмдэглэж байна.

МУИС-ийн захирал, доктор Р.Бат-Эрдэнэ Дээд боловсролын шинэчлэлийн бодлогын зөвлөх байх үеийн судалгааны тайландаа “дэлхийн улс орнуудын дээд боловсролын реформын бодлого нь үндсэндээ чанар, инноваци, зохицуулалт, өрсөлдөөн, хариуцлага, эрх чөлөөний хэм хэмжээ, бие даасан байдал, судалгааны чадавхыг нэмэгдүүлэх асуудал болж байгааг тэмдэглэсэн байдаг” (“Монголын дээд боловсролын реформ: шийдэл, үр дагавар”, 1914).

Мөн БСШУЯ-ы саяхан дэвшүүлсэн чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд, *“Шинжлэх ухааны бодлого” нь, зах зээлийн эрэлт хэрэгцээний чанарын хувьсалд суурилсан удирдлага, санхүүжилтийн үр ашигтай тогтолцоог төлөвшүүлэн, “боловсрол-шинжлэх ухаан”-ы цогц хамтын ажиллагааг дэмжихэд чиглэнэ*” хэмээн тодорхойлсон байна. Иймд, шинжлэх ухааны томоохон төв болох их сургуулиудын гол бодлого нь боловсрол-шинжлэх ухааныг нэгэн цогц болгож хөгжүүлэх эрмэлзэл байх нь.

Инновацийг дэмжин хөгжүүлэхэд харгалзах зүйлс байдаг байна. Тэдгээрээс дараах хоёр зүйлийг авч үзье. Тухайлбал, дээд боловсролын салбар, их сургуулиудад инноваци нэвтрүүлэх үндсэн зарчмыг судлаачид:

- Шударга, тэгш байх ардчилах зарчим
- Суртахууны эрхэм чанар, бүхий хүмүүнлэг зарчим
- Өргөн боломж бүхий нээлттэй зарчим
- Өөр өөр хэв шинжит сургууль хөгжих, олон хэв шинжит тогтолцоо
- Дээд боловсролын улсын хэмжээний чанарын стандарт болон бүс нутгийн онцлогийг харгалзсан стандартчиллын зарчим хэмээн тодорхойлсон байна.

Мөн онолын хувьд инновацийг хэмжих дараах үндсэн шалгуур байдаг байна. Энэ нь:

- Шинжлэх ухаан, технологийн хувьд шинэлэг,
- Амьдрал практикт хэрэгжихүйц,
- Зах зээлд арилжаалагдах шинжтэй
- Хэрэглэгчдийн тодорхой эрэлт хэрэгцээг хангахуйц байх явдал юм.

Б.Инновацид эрдэмтэн, профессор, багш, судлаачдын оруулах хувь нэмэр

Манай улсын эрдэмтэн, профессоруудын дийлэнх нь дээд боловсролын салбарт ажилладаг тул инновацийг хөгжүүлэх гол хүч энд байгаа гэсэн үг. Эдгээр эрдэмтэн профессоруудаас нэг хэсэг нь дээд боловсролын салбарын бодлого төлөвлөлт болон их, дээд сургууль, коллежийн удирдлагаар ажилладаг тул тэдний эрхэлсэн ажил албатай холбоотой үүрэг оролцоо, нийгэмд оруулах хувь нэмэр багш, судлаачдынхаас ялгаатай. Энэ утгаар нь авч үзвэл, тэдэнд хэрэгжүүлэх, хийж гүйцэтгэх их ажил буй билээ. Тухайлбал:

1. БСШУЯ болон шинжлэх ухаан технологи, инновацийн бодлого, хэрэгжилт хариуцсан сайд удирдлага, газар, хэлтэс, эрдэмтдийн өмнө дараах хүлээлт хэрэгцээ шаардлага тулгарсан, үүрэг оролцоо чухлыг олон эшт сурвалжуудад тулгуурлан авч үзвэл:
 - Дээд боловсролыг тогтвортой хөгжихүйц болгон хувирган өөрчлөх, дээд боловсролын хөгжил шинэчлэлийг улс орныхоо хөгжил дэвшлийг түргэтгэх хөшүүрэг болгох суурь шийдэл хийх
 - Манай улсын дээд боловсролын тогтолцоонд эдүгээ шинэ тутам байгаа инновацийг дэмжих зохистой бүтэц, харилцаа бий болгох, энтрепренёр үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг өрнүүлэн дэмжих, дээрх чиглэлээр их сургуулиудад хууль эрхзүйн чадавх, бизнес хөгжлийн менежер, технологи дамжуулах туршлага бүхий оюуны өмчийн эрхзүйч зэрэг чухал мэргэжилтнүүд бэлтгэх бодлого боловсруулах
 - Инноваци хэрэгжүүлэх зорилгыг төрийн бодлогоор дэмжихийн зэрэгцээ, их сургуулийн инноваци үйл ажиллагаатай үндэсний инновацийн тогтолцоот дэмжлэгийг уялдуулахад санаачилга гаргах. Ингэснээр их сургуулиудын үйл ажиллагаа эрчимжиж, шинжлэх ухааны болон, эдийн засгийг дэмжих байгууллага

- хоорондын хамтын ажиллагаа идэвхжих учиртай байна.
- Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого хэрэгжүүлэх үйлсэд чиглүүлэх, их сургуулийн хөгжлийг улс орнуудын хүрэн дэх өрсөлдөөн болгоход бодлогын дэмжлэг үзүүлэх
 - Их, дээд сургуулиудыг улсын хөгжилд оруулсан хувь нэмэр, чанартай боловсролын үйлчилгээгээр нь магадлан итгэмжлэх, заримыг хаах, нэгтгэх, чадамжтайг бие даалгах зэрэг уян хатан, олон гарцтай зохицуулалт хийх,
 - Боловсролын эрхзүй, маркетинг, менежмент зэрэг зохион байгуулалт, төлөвлөлтийн цогц шинэчлэл хийж, дээд боловсролын эрхзүйн орчинг сайжруулахад ахиц гаргах
 - Их сургууль дундын технологи арилжааны төв, технологийн брокер, чанарын хяналт үнэлгээ, баталгааны асуудлыг авч үзэх
 - Боловсрол дахь олон хэвшлийн сургуулийн хэв шинжит тогтолцоо, тэнцвэрийг
 - хангах, хувийн хэвшлийн байр суурийг өөрчлөх, оролцоог нэмэгдүүлэх зэрэг зүйлд анхаарлаа төвлөрүүлэх зорилт зэрэг олон зүйл байна.
2. Их, дээд сургуулийн удирдлага, менежер, судалгааны төвийн захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирлуудын өмнө дараах хүлээлт, шийдвэртэй арга хэмжээ чухалчлагдаж байдаг. Тухайлбал,
- Сургууль, тэнхимээрээ дэлхийн нэртэй их, дээд сургуулиудын хөгжил, бодлого, чиг хандлагад ойртож, нээлттэй хөгжих
 - Их сургууль-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэл, бизнесийн холбоог бэхжүүлэх
 - бүс улс, нутгийн хэмжээнд идэвхтэй хамтран ажиллах
 - Дээд боловсролын чанарын өөрчлөлт буюу шинэчлэлийн инновацийг баримжаалан эрдэм шинжилгээ, туршилт, бүтээн байгуулалт, инновацийн тэргүүлэх чиглэлийг томъёолон хэрэгжүүлэх алхамууд хийх
 - Технологийн ба эдийн засаг, нийгмийн инноваци, удирдлага зохион байгуулалт, маркетингийн инноваци, стратеги ба мэдээллийн инновацийг их сургууль, тэнхимийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх
 - Шинжлэх ухаанд суурилсан, байгаль
- экологид ээлтэй технологи, мэдлэг үйлдвэрлэхэд их сургуулиуд хамтран ажиллах, түншлэл бий болгох
- Сургалт-судалгаа-бизнес үйл ажиллагааны төв нэгж, лаборатор байгуулах
 - Багшийн хөгжил, байгууллагын соёл, суралцагч байгууллага зэрэг хөгжил дэвшил рүү чиглэсэн ажлуудыг эрчимтэй өрнүүлэх
 - Мэргэжил, агуулгын давхардлыг арилган, судлах хичээлийн төрөл, сонголтыг шинэчлэх замаар сургууль, тэнхим, эрдэмтдийн эрдэм ухаан, хүч нөөцийг төвлөрүүлэх,
 - Эмэгтэй эрдэмтдийн үнэлэмжийг дээшлүүлэх. Эрүүл мэнд, их хөдөлмөрөөр бий болдог шинжлэх ухааны доктор, салбарын докторын ялгамжит зэрэглэлийг аливаад харгалздаг байх, ахмад эрдэмтэд, профессорыг үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх, тэдний оюун ухаан, чадвар туршлагыг ашиглах зэрэгт дорвитой өөрчлөлт хийх
 - Тэргүүлэх их сургуулиудад дотоодын болон олон улсын түвшний хамтарсан сургалт, судалгааны хөтөлбөр, төсөл боловсруулах, богино, урт хугацаагаар гадаадын нэрт эрдэмтэн, мэргэжилтэн, профессоруудыг урин ажиллуулах, ноу-хау технологийн чиглэлийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах. Ингэснээр дэлхийн болон олон улсын зэрэглэлд ойртох боломжийг нэмэгдүүлэх.
 - Олон улсын чанартай эрдэм шинжилгээний хурал, хамтын ажиллагаанд бүтээлч, бүтээгч эрдэмтдийг өргөнөөр хамруулан хөгжих боломж олгох. Ингэснээр тус сургуулийн эрдэм шинжилгээ, сургалт, инновацийн чиг хандлага, ирээдүйг тодорхойлоход эрдэмтдийн үүрэг хариуцлага асар нэмэгдэх юм.
3. Тэнхимийн эрхлэгч, профессорын багийн ахлагч эрдэмтэд эн түрүүн дараах зүйлд анхаарлаа хандуулбал шинэчлэлийн эхлэлд их хувь нэмэр оруулах нь дамжиггүй билээ. Үүнд:
- Тухайн тэнхим, профессорын баг эрдэм шинжилгээ, судлалын тэргүүлэх чиглэл, инновацид холбогдох зүйлээ хэлэлцэн тодорхойлох, тэр чиглэл рүү бодлого боловсруулан төлөвлөж зорих
 - Тэнхим, багш нарын үйл ажиллагаа,

- сургалтыг сургуулийнхаа шинэчлэлийн инноваци, эрдэм шинжилгээ, туршилт, бүтээн байгуулалтын бодлого үйл ажиллагаатай уялдуулах
 - Хөтөлбөрт суурилсан сургалтын зохион байгуулалтад шилжиж, суралцагчийн дээд боловсролын хөтөлбөр сонгох чиглэл, мэргэжлээрээ хөрвөж ажиллах боломжийг улам нэмэгдүүлэх
 - Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн хувьд өргөн суурьтай болгох, магистрантур, докторантурын сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр бүтээлт тал, шинжлэх ухаанд оруулах хувь нэмэрт тавих шаардлагыг эрс чанаржуулах
 - Олон улсын дээд боловсролын стандарт, чанарын баталгаа, стратегийг баримжаалсан стратегийн сонголт хийж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, заах аргазүй зэргээ бусад улс орнуудад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд шинэчлэх
 - Шилдэг хамтын хөтөлбөр, чанартай сургалтын агуулга, аргазүйн төсөл боловсруулж ажиллах
 - Мэргэжлийн тэнхим хоорондын хамтын ажиллагаа
 - Багш, эрдэмтдийн чадамж, ажлын чанар, шинжлэх ухаан, технологид оруулсан тодорхой үр дүнг үнэлэх зэрэг олон асуудал бий юм.
4. Эрдэмтэн багш, профессорууд их сургуулийн хөгжил дэвшил, инновацид хамгийн их үүрэг гүйцэтгэдэг. Иймд тэдний өмнө тулгамдсан асуудал ч их бий юм. Тухайлбал,
- Бүтээгч дээд боловсролын зохист агуулга, аргазүй, инновацийг судлан нэвтрүүлэх
 - Дээд боловсролын өөрчлөлт, шинэчлэлийн инновацийг шинжлэх ухааны судалгаа, чанарын хөтөлбөрт суурилсан шинэчлэл болгосноор, мэдлэг бүтээх–мэдлэгийг хэрэглээ-бүтээгдэхүүн болгон хувиргах
 - Нийгмийн хариуцлага хүлээх чадавхтай, бүтээлч мэдлэг, чадвар, хандлагыг инноваци болгон хувиргах
 - Өөрчлөлт бүхий шинэ нийгэмд зохицон амьдарч чадах, мэргэжилтний олон улсын жишигт тэнцэх, өөрийн орны эрэлт хэрэгцээг хангасан мэргэжилтэн, бүтээгч иргэн төлөвшүүлэх, бэлтгэн гаргахад санал санаачилга гаргах
 - Докторантурын сургалтыг инновацитай холбох, докторантуудтай хамтарч ажиллах, багш эрдэмтэд хоорондоо баг болон

ажиллаж шинэ бүтээл гаргах

- Эрдэмтэн багш нар дээд боловсролын үзэл баримтлал, чиг хандлагыг шинэ үзлээр харж, чанарыг сайжруулахад санал санаачилга гарган холбогдох газарт нь уламжилж ажиллах. Энэ саналыг нь дэмжихэд их, дээд сургууль, консорциум анхаарах.
- Ажиллаж байгаа их сургуулиа дэлхийн болон бүсийн нэртэй сургуулиудын хөгжил, бодлогод ойртож, нээлттэй хөгжихөд нь бүтээлч хувь нэмэр оруулах
- Улс орнуудын болон өөрийн орны хүрээнд бусад эрдэмтэдтэй хамтран ажиллаж, үзэл бодол, оюуны хүчээ нэгтгэх, эрдэмтдийн нэгсмэл орон зайг бий болгох зэрэг хэрэгцээ байсаар байна.

Их сургуулийн эрдэмтэн багшийн төгс загвар нь “Бүх шавийнхаа сэтгэл зүрхэнд зааж сургасан бүхнээрээ амьдралын туршид нь оршиж чадсан, боловсролын болон мэргэжлийн салбартаа тэргүүлэгч, улс орондоо болон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, манлай оюунлаг, их эрдэмтэн “магна” багш” байх юм (Энхтүвшин, 2006). Мөн мэргэжлийн мэдлэг, ур чадвараараа шалгаран, төгс мэргэшсэн, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрээрээ мэргэжлийн салбар, улс, олон улсын хэмжээнд нэрд гарсан, нийгэмшил төлөвшил нь өндөр хэмжээнд хүрсэн, судалгааны арга туршлагатай, бусад багш нартаа орчин үеийн шаардлагад нийцсэн зөвлөгөө өгч чаддаг, эрдэмтэн, профессор, “хөгжсөн багш” байх болно.

Багш, судлаачдын инновацид оруулах хувь нэмэр бол тэдний шүүмжит сэтгэлгээ хийгээд, орон зай, цаг хугацаа сэдвийн хүрээнд баригдалгүй чөлөөтэй сэтгэх, хил хязгааргүй бодох-асуух-зөвлөлдөх үйл, хэрхэхээ мэдэх (know how), шинэ санаа, хил хязгааргүй асуух-зөвлөлдөх, туршлага практик зэргээс эхэлнэ. Сэтгэлгээндээ, бүтээлчээр сэтгэх загвар болох Блуммийн таксономын *мэдлэг- ойлголт-хэрэглээ-дүн шинжилгээ-нэгтгэл үнэлгээ* гэсэн таван үйлийг, тэр тутмаа сүүлийн хоёр шатлалыг эрхэмлэх нь чухал юм.

5. Эрдэм шинжилгээний ажилтан, зохион бүтээгч эрдэмтэд эрдэм судлалаараа тухайн сургуулийг тэргүүлэх үүрэгтэй байдаг. Тэд өөрсдийн судалгаанд ач холбогдол өгөхийн зэрэгцээ сургуулийнхаа эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн ирээдүйг харж дараах чиглэлд түлхүү анхааран дэмжиж ажиллах шаардлага бий юм:
- Мэдлэг үйлдвэрлэдэг эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн цогцолборуудыг

байгуулан ажиллахад болон эрдэмтэн, багш, судлаач, зохион бүтээгчдийн санал санаачилгыг идэвхжүүлэх, манлайлах, судалгааны аргазүйн дэмжлэг үзүүлэх

- Дээд боловсролын талаарх судалгаа шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгоход санаа бодол, оролцоогоо нэмэгдүүлэх
- Тус тусын судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын бүтээмжийг их сургуулийнхаа эрдэм шинжилгээ, судалгааны болон үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого хэрэгжүүлэх үйлсэд чиглүүлэх
- Инновацийн үйл ажиллагааг өргөжүүлэн, оюуны бүтээл, мэдлэгийг зах зээлийн эргэлтэд хурдацтай нийлүүлэх үйлсэд бүтээлчээр сэтгэгч-бүтээгчийн байр сууринаас хандаж, эрдэмтний хувь нэмрээ оруулах зэрэг чухал асуудал бий юм.

ДҮГНЭЛТ

Өгүүллийн эцэст, хоёр эрдэмтний үгийг хүргэж, их, дээд сургуулийн эрдэмжилт, инноваци хөгжил бүхэн сургалт-үйлчилгээнээс эхэлнэ гэсэн дүгнэлтээр үгээ төгсгөө. Академич Б.Жадамбаа 2012 онд дэлхийн их сургуулийн захирлуудын олон улсын чуулга уулзалтад тавьсан “Дээд боловсролын шинэчлэлийн чиг хандлагын өөрчлөлт” илтгэлдээ: “Дээд боловсролын шинэчлэлийн чиг хандлагын өөрчлөлтийг тогтвортой хөгжил бүхий, суралцагчидтайгаа хамт хөгжигч профессор, багш нар, тогтвортой хөгжих бололцоотой төгсөгчид байх болно хэмээн тэмдэглэсэн бол профессор Б.Бямбаа, “Их сургуулийн менежментийг чадваржуулж, эрдэм шинжилгээ-боловсрол-үйлдвэрлэл- бизнесийн тогтолцоог сайжруулахад чиглэх шинэчлэл нь монголын дээд боловсролын сургалтын бодлогын гол хандлага байх болно” хэмээн үзсэн байдаг.

Энэчлэн их сургуулиуд үйл ажиллагаагаа сургалт-судалгаа-үйлдвэрлэл бизнест чиглэсэн хамтын үйл ажиллагаа, хөгжил дэвшил, чанар, инноваци гэсэн цогц шийдэл рүү хандуулан, хөгжлийн шаталсан зорилт бүхий эрхэм зорилго, алсын хараагаа хэрэгжүүлэх нь чухал болж байна. Иймд энэ их үйлсийн гол хүч болсон эрдэмтэн профессор, багш нарын идэвх, санал санаачилга, үр бүтээлт хөдөлмөр, ухаалаг шийдэл дээд боловсролын хөгжил дэвшил, инновацийн ирээдүйг тодорхойлох их хүлээлт болох билээ.

Эцэст нь тэмдэглэхэд, энэ өгүүллийн хүрээнд хөндсөн чиглэлүүдээр МУБИС-ийн удирдлагын

багийн санал санаачлага, үйл ажиллагааны шинэчлэл нь менежмент сайтай, эрчимтэй, тасралтгүй өрнөж байгааг олж харж, үйл ажиллагаанд нь оролцож байна, дэмжин урам өгч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бат-Эрдэнэ, Р. (2014). Монголын дээд боловсролын реформ: шийдэл, үр дагавар. *Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл*. Улаанбаатар
- Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам. (2011-2015). *БШУЯ-ы үзэл баримтлал, баримт бичгүүд*. Улаанбаатар
- Бямбаа, Б. (2012). Нэг дэлхий-нэг боловсрол. *Дэлхийн их сургуулийн захирлуудын олон улсын чуулга уулзалтын илтгэлүүдийн эмхэтгэл*. Улаанбаатар
- Ганзориг, Ч., Төмөр-Очир, С. (2012). Монгол Улсад өндөр технологийн аж үйлдвэр, инновацийг хөгжүүлэхэд их сургуулийн гүйцэтгэх үүрэг: Энтерпренёр судалгааны их сургуулийн хувьд. *Даяариллын эрин үеийн дээд боловсролын шинэчлэл: сорилт, туршилага, арга барил эмхэтгэл*. Улаанбаатар
- Дамдинсүрэн, Б. (2012). Дээд боловсролын даяаршил ба Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн инноваци. *“Даяариллын эрин үеийн дээд боловсролын шинэчлэл: сорилт, туршилага, арга барил” эмхэтгэл*. Улаанбаатар
- Жадамбаа, Б. (2010). Дээд боловсролын хөгжлийн хандлагын өөрчлөлт, шинэчлэл. *“Дээд боловсролын чанар-бидний оролцоо, хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөний эмхэтгэл*. Улаанбаатар
- Тэгшжаргал, Н. (2012). Их дээд сургууль дахь инновацийг хөгжүүлэх хэрэгцээ, чиглэл, төлөв байдал. *“Дээд боловсролын шинэчлэл-сургалтын технологи” илтгэлүүдийн эмхэтгэл*. Улаанбаатар
- Энхтүвшин, Б. (2006). *Багийн урлаг*. Улаанбаатар